

**СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/эхний хагас жилээр/

2022.06.15

Сүмбэр

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	Ёс зүйн зөвлөлийн нээлтийн "Өглөөний цай" арга хэмжээ зохион байгуулах.	Албан хаагчдын дунд хамт олонч эерэг уур амьсгал болон ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, "Ёс зүйн зөвлөл"ийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулах зорилгоор "Өглөөний цай" арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний үеэр ёс зүйн зөвлөлийн ажиллах бүрлэдэхүүн томилсон тушаал, журам, зөвлөлийн бүрэн эрх үүрэг, зохион байгуулах ажил арга хэмжээ болон ёс зүйн зөрчил шалгах үндэслэлийн талаар сургалт зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн эрхэмлэх ёс зүйл" боршур тараан, албан хаагчдын дунд "Миний сайн муу тал" саналын хуудас аялуулан, мөн 3 дугаар сарын "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулж ажиллаа. "Ёс зүйтэй албан хаагч"-аар 3 дугаар багийн Засаг дарга Т.Гантулга шалгарсан. Уг арга хэмжээнд 30 албан хаагч хамрагдахаас 26 албан хаагч хамрагдсан.
2	Албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, цаг ашиглалтын талаар нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулах.	Байгууллага нь албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин болон ажлын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, холбогдох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдынхаа сэтгэл ханамжийн судалгааг явууллаа. Санал асуулгыг цахим хэлбэрээр 9 асуулгыг бэлтгэж албан хаагч бүрт линкийг явуулж бөглүүлсэн ба санал асуулгад нийт ажилчдын 66.6хувь нь буюу 18 албан хаагч оролцлоо. Асуулт бүрт сайн, дунд, муу гэсэн сонголттой үнэлгээг өгөхөөр төлөвлөсөн. Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийхэд нийт албан хаагчдын дийлэнх буюу 77.8 хувь нь өөрийн ажилдаа сэтгэл ханамжтай, 83.3 хувь нь ажлын байран дээрээ мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломж байна гэж дүгнэсэн бол хамт олны ёс зүй, төлөвшил, цаг ашиглалтын хувьд нийт оролцсон албан хаагчдын 72.6 хувь нь муу буюу дунд гэсэн үнэлгээ өгсөн байгаа нь нэг хамт олон болж нэгдээгүй бие биенээ үл хүндэтгэсэн, үзэл бодлын зөрүүтэй байдал байдаг, мөн ажиллах нөхцөл, техник тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй байдалд 66.7 хувь нь муу буюу дунд гэж хариулсан нь ажиллах орчин нөхцөл, өрөө тасалгааны тохижилт хангалтгүй байгаа байдал харагдаж байна. Нийт санал асуулгад оролцсон албан хаагчдаас нээлттэй санал асуулгад 8 буюу 44.4 хувь албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж унаа хоолны зардал нэмэх талаар саналыг ирүүлсэн нь байна.
3	Монгол Улсын засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн	Ёс зүйн зөвлөлийн гишүүн Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн М.Долгормаа нь "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ээр албан хаагчдад сургалт зохион байгуулан ажилласан.

	ёс зүйн дүрэм"-ээр албан хаагчдад сургалт зохион байгуулах.	
4	"Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх" сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгуулах.	Хугацаа болоогүй
5	Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль" болон "Архи тамхины хор хөнөөл" сэдвээр сургалт зохион байгуулах.	Ёс зүйн зөвлөлийн гишүүн жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн Б.Сувдшүрэн нь албан хаагчдад "Архины хор нөлөө" сэдвээр сургалт зохион байгуулсан.
6	Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-тэй хамтран эцэг эхийн өдрөөр албан хаагч гэр бүлийн гишүүдийн дунд нөхөрсөг тэмцээн зохион байгуулах.	Биелээгүй.
7	Аймгийн ГБХЗХГ-тай хамтран албан хаагчдад "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль" болон "Хүүхэд хамгааллын тухай хууль" тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах.	Аймгийн Цагдаагийн хэлтсийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Жавхланг урьж нийт албан хаагчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар сургалт зохион байгуулж, уг сургалтаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын талаарх ойлголт, төрийн албан хаагчдын гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээний талаар мэдлэг олгосон.
8	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" болон бусад эрх зүйн актуудаар мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байрлуулж, албан хаагчдад бэлтгэн тараах.	"Төрийн албан хаагчийн эрхэмлэх ёсон зүйл" боршур бэлтгэн нийт албан хаагчдад тараан, байгууллагын мэдээллийн самбарт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ээр 2 төрлийн мэдээлэл бэлтгэн байршуулсан.
9	Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримтын дагуу тухай бүр хуулийн хугацаанд шалган шийдвэрлэх.	Тайлант хугацаанд төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн зөрчил, дутагдал бүртгэгдээгүй.
10	Ёс зүйн зөвлөлийн гишүүд 7 хоногт 1 удаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэнэтийн эргүүл, шалгалт хийх.	Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагийн жижүүр болон албан хаагчдыг 21 удаагийн гэнэтийн эргүүл шалгалтыг хийсэн.
11	Сар бүр байгууллагийн "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулж, урамшуулах.	Албан хаагчийг урамшуулах, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор 1 удаа "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулсан байна.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Э.САРНАЙ